



ГОВЬСҮМБЭР АЙМАГ
БАЯНТАЛ СУМЫН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2025 оны 09 сарын 30 өдөр

Дугаар А/102

Баянтал сум

Хоршоо хөгжүүлэх сангийн төсөл
батлах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 59 дүгээр зүйлийн 59.1.1, 59.1.23, 66 дугаар зүйлийн 66.1, Захиргааны ерөнхий хуулийн 43 дугаар зүйлийн 43.1, 46 дугаар зүйлийн 46.1, Төсвийн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.2.3, Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн Сайдын 2021 оны А/361 дүгээр тушаалын "Хоршоо хөгжүүлэх сангаас хөнгөлөлттэй зээл олгох, сонгон шалгаруулах, эргэн төлүүлэх хяналт тавих журам"-ын 3.4.2, 3.4.3, 3.4.4, 6.7, 6.8 дахь заалтыг үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1.Суманд жижиг дунд үйлдвэрийг хөгжүүлэх, ажлын байр нэмэгдүүлэх зорилгоор хоршоо хөгжүүлэх сангийн төсөл сонгон шалгаруулах комиссын хурлаас батлагдсан Хүнс, хөдөө аж ахуйн үйлдвэрлэлийн чиглэлээр "Сүүн цагаан идээ боловсруулах цех" төсөл

2.Барилгын материалын үйлдвэрлэлийн чиглэлээр "Блокын үйлдвэрлэл өргөжүүлэх" төслийг тус тус баталсугай.

3.Батлагдсан төсөлд шаардагдах 129,000,000 (Нэгэн зуун хорин есөн сая) төгрөгийг Хоршоо хөгжүүлэх сангаас олгохыг ерөнхий нягтлан бодогч (Б.Солонгомаа)-д зөвшөөрсүгэй.

4.Хоршоо хөгжүүлэх сангаас зээл авсан хоршоодын төслийн хэрэгжилт, зээлийн эргэн төлөлт, зарцуулалтад хяналт тавьж ажиллахыг Хоршоо хөгжүүлэх сангийн ерөнхий нягтлан бодогч (Б.Солонгомаа)-д үүрэг болгосугай.

ЗАСАГ ДАРГА



Э.БАТТУЛГА